

Төлөвлөгөөт хяналт шалгалт  
хийсэн дүнгийн тухай

**НЭГ. ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ЗОРИЛГО**

Булган аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт аудитын албаны 2019 оны хяналт шалгалтын нэгдсэн төлөвлөгөөний дагуу Булган сумын дөрөвдүгээр цэцэрлэгийн 2017, 2018 оны санхүү, аж ахуйн үйл ажиллагаанд Монгол Улсын Төсвийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Боловсролын тухай, Сургуулийн өмнөх боловсролын тухай хуулиуд болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан бусад эрх зүйн актуудын хэрэгжилтийг шалгаж, зөрчил дутагдал илэрсэн тохиолдолд холбогдох хуулийн дагуу шийдвэрлэх, аливаа эрсдлээс урьдчилан сэргийлэх, цаашид давтан гаргахгүй байх талаар мэргэжил арга зүйн заавар, зөвлөгөө өгөхөд оршино.

**ХОЁР. ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН БҮРЭЛДЭХҮҮН, ХУГАЦАА**

Санхүүгийн хяналт аудитын албаны даргын баталсан 2019 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн 1/05 дугаар удирдамжийн дагуу хяналт шалгалтыг Санхүүгийн хяналт шалгалтын улсын байцаагч Ж.Оюун 2019 оны 04 дүгээр сарын 10-аас 2019 оны 05 дугаар сарын 30 хүртэл хугацаанд хийж гүйцэтгэлээ.

Шалгалтын хугацаа удааширсан шалтгаан нь эрхлэгч П.Ариунаа, нягтлан бодогч асан Б.Эрдэнэчимэг нар албан ажлаар гадаад улс руу зорчсон, улсын байцаагч Ж.Оюун би мэргэшсэн нягтлан бодогчийн эрх олгох сургалт, шалгалтанд хамрагдсантай холбоотой.

**ГУРАВ. ШАЛГАЛТАНД ХАМРАГДСАН АСУУДЛУУД**

Булган сумын 4-р цэцэрлэгийн 2017, 2018 оны касс, харилцах дансны гүйлгээг санхүүгийн анхан шатны баримттай тулган шалгасны зэрэгцээ цалин хөлс, олговор, албан томилолтын бодолт, олголт, хүнсний бүтээгдэхүүн, бараа материалын худалдан авалт, зарцуулалт, үлдэгдлийн байдал, нэмэлт орлого түүний бүрдүүлэлт, зарцуулалт, шатахууны олголт, зарцуулалт, хэтрэлт хэмнэлт, эд хөрөнгийн тооллого тооцоо бодолт, санхүү, төсвийн ил тод байдлын хэрэгжилт, “Шилэн дансны тухай хууль”-ийн хэрэгжилт зэрэг хяналт шалгалтын удирдамжид заагдсан асуудлуудыг хамруулав.

**ДӨРӨВ. ШАЛГАЛТАНД ХАМРАГДСАН ОБЪЕКТЫН ТАЛААРХ  
ТОВЧ МЭДЭЭЛЭЛ**

Булган сумын 4-р цэцэрлэг нь 2017 онд эрхлэгч 1, үндсэн багш 5, туслах багш 4, тогооч 2, арга зүйч, нярав, үйлчлэгч, угаагч, сахиул тус бүр 1 нийт 17 орон тоотой, бэлтгэл, ахлах, дунд, бага гэсэн үндсэн бүлэгт дунджаар 125 хүүхэд хамрагдсан бол 2018 онд 17 орон тоотой, үндсэн 4 бүлэгт дунджаар 138 хүүхэд хамруулж сургуулийн өмнөх боловсролын үйл ажиллагааг хүргэсэн байна.

Тус цэцэрлэгийн санхүү, аж ахуйн үйл ажиллагаанд нэгдүгээр гарын үсгийг 2017 оны 01 сарын 01-ээс 2018 оны 12 сарын 31-ний өдрийг хүртэл П.Ариунаа,

хоёрдугаар гарын үсгийг 2017 оны 01 сарын 01-ээс 08 сарын 22-ныг хүртэл Д.Баярчимэг, 2017 оны 08 сарын 23-аас 2018 оны 12 сарын 31-ний өдөр хүртэл Б.Эрдэнэчимэг нар зурсан ба сумын төрийн санд бүртгэлийн 100041415206 дугаар, нэмэлт санхүүжилтийн 100041415410 дугаар данстайгаар хөрөнгө мөнгийг захиран зарцуулж ирсэн ба нягтлан бодох бүртгэл болон няравын тайланг (2018 оноос) санхүүгийн тооцоолох “CTS” программаар бүртгэн хөтөлжээ.

Шалгалтанд хамрагдсан хугацаанд тус байгууллагын нярав эд хариуцагчаар А.Сувдмаа ажилласан байна.

Булган сумын 7-р цэцэрлэгийн нягтлан бодогч Д.Баярчимэг, Б.Эрдэнэчимэг нар тус байгууллагын нягтлан бодогчийн албан тушаалыг, нярав А.Сувдмаа 2017 оны 01 сарын 01-ээс 10 сарын 01 хүртэл угаагчийн албан тушаалыг, бүлгийн багш Б.Сэлэнгэ 2018 оны 10 сарын 01-ээс 10 сарын 31-нийг хүртэл дуу хөгжмийн багшийн албан тушаалыг тус тус хавсран гүйцэтгүүлж, үндсэн цалингийн 40 хувийн нэмэгдэл цалин олгосон байна.

### **ТАВ. ӨМНӨХ ШАЛГАЛТЫН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ**

Булган сумын 4-р цэцэрлэгийн 2017, 2018 оны санхүүгийн тайлан нь аудитын түүвэрт хамрагдсан байна.

2018 онд аймгийн Татварын хэлтсээс тус цэцэрлэгийн 2013-2017 оны албан татвар ногдуулалт, төлөлтийн байдалд хяналт шалгалт хийж, ахмадуудад олгосон тэтгэмж, иргэдэд олгосон 1137.5 мянган төгрөгөөс хувь хүний орлогын албан татвар суутгаагүй, суутган авсан боловч төсөвт төлөөгүй, ажилчдаас суутгасан 33.9 мянган төгрөгийн татварыг дутуу тайлагнасан зөрчлийг илрүүлсэн байна. Уг зөрчилд нийт 208.6 мянган төгрөгийг нөхөн татвар, торгууль, алданги оногдуулсаныг бүрэн барагдуулсан байна.

2017 оны 01 сард Нийгмийн даатгалын хэлтсээс даатгуулагчийн хүсэлтийн дагуу даатгуулагч Л.Бумбатын 1995-2002 онуудын нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн байдлыг шалгахад хүүхэд асрах чөлөөтэй байх хугацааны хөдөлмөрийн хөлс түүнтэй адилтгах орлогоос нийгмийн даатгалын шимтгэл төлөөгүй байсан зөрчилд улсын байцаагчийн актаар шимтгэл, алдагийн нийт 95.8 мянган төгрөгийг төлүүлэхээр тогтоосныг цэцэрлэгийн төсвөөс аймгийн НДХэлтсийн нэгдсэн сангийн ХААН банкин дахь 5270260598 тоот дансанд 2017 оны 02 сарын 24-нд 83.2 мянган төгрөг, 2017 оны 03 сарын 07-нд 12.6 мянган төгрөгийг тус тус төвлөрүүлсэн байна.

2017 оны 05 сард Нийгмийн даатгалын хэлтсээс тус цэцэрлэгээс ирүүлсэн хүсэлтийн дагуу даатгуулагч Б.Сэлэнгэ, Б.Сүнжидмаа нарын нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн байдлыг шалгаж, 2017 оны 01 сарын хүүхэд асрах чөлөөтэй байх хугацааны нийгмийн даатгалын шимтгэл 38.4 мянган төгрөг төлөгдөөгүй байсан зөрчлийг илрүүлж улсын байцаагчийн актаар шимтгэл, алдагийн нийт 48.7 мянган төгрөг төлүүлэхээр тогтоосныг цэцэрлэгийн төсвөөс аймгийн НДХэлтсийн нэгдсэн сангийн ХААН банкин дахь 5270260598 тоот дансанд 2017 оны 05 сарын 30-нд төвлөрүүлсэн байна.

### **ЗУРГАА. ШАЛГАЛТЫН ЯВЦАД ХИЙГДСЭН АЖИЛ, ШАЛГАЛТАНД ХАМРАГДСАН АСУУДЛУУД**

Булган сумын 4-р цэцэрлэгийн 2017, 2018 оны касс, харилцах, аж ахуйн баримт, хөрөнгийн бүртгэл, байгууллагын удирдлагын гаргасан шийдвэр, цалингийн карт, ажлын цаг ашиглалтын бүртгэл, журнал, тайлан баланс, хөдөлмөрийн дотоод журам, агуулахын бүртгэл, дотоод хяналт хийсэн шалгалтын материал болон бусад баримт материалуудад тулгуурлан эрхлэгч П.Ариунаа, арга зүйч Б.Нансалмаа, нягтлан бодогч асан Б.Эрдэнэчимэг, нягтлан бодогч асан Д.Баярчимэг, нярав А.Сувдмаа нарыг байлцуулан төлөвлөгөөт хяналт шалгалтыг хийв.

**6.1. Санхүүгийн эх үүсвэрийн бүрдүүлэлт, зарцуулалтын талаар:**

**2017 онд** улсын төсвөөс авах санхүүжилтийг 255538.5 мянган төгрөгөөр төлөвлөж, төсвийн тодотголоор 29645.2 мянган төгрөг нэмж, зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 285183.7 мянган төгрөгөөр баталсан байна.

Гүйцэтгэлээр санхүүжилтийг бүрэн авч, нэмэлт санхүүжилтийн дансаар БСУГазраас улсын математикийн 53-р олимпиадад оролцогчдын хоолны зардалд 144.0 мянган төгрөг орж бүгд 285327.7 мянган төгрөгийн эх үүсвэр бүрдүүлэн ажиллаж, үйл ажиллагааны зардалд 285224.0 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 103.7 мянган төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Ажиллагсадтай холбоотой зардалд 159710.1 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардалд 52730.0 мянган төгрөг, нормативт зардалд 38885.8 мянган төгрөг, хангамж бараа материалын зардалд 3880.9 мянган төгрөг, урсгал засварын зардалд 1168.4 мянган төгрөг, албан томилолтын зардалд 97.0 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардалд 943.7 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 2684.9 мянган төгрөг, хичээл сургалт үйлдвэрлэлийн дадлага хийх зардалд 446.6 мянган төгрөг, нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардалд 5100.0 мянган төгрөг, хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад таван жил тутамд олгох тэтгэмжид 3650.7 мянган төгрөг, төсвийн дотоод эх үүсвэрээр тоног төхөөрөмж, тавилга эд хогшил худалдан авахад 15925.9 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Батлагдсан төсөвт орсон өөрчлөлтийг зардлын ангиллаар нь харуулбал: ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл 470.3 мянган төгрөг, цэвэр бохир ус 1000.0 мянган төгрөг, түлш халаалт 1500.0 мянган төгрөг, бага үнэтэй түргэн элэгдэх ахуйн эд зүйлс 15735.7 мянган төгрөг, хоол хүнс 465.0 мянган төгрөг, нормын хувцас зөөлөн эдлэл 100.0 мянган төгрөг, урсгал засвар 1000.0 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардал 600.0 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардал 2000.0 мянган төгрөг, хичээл үйлдвэрлэл дадлага хийх 2500.0 мянган төгрөг, нэг удаагийн тэтгэмж урамшуулал 5100.0 мянган төгрөг нийт 30471.0 мянган төгрөгийг нэмж, цалин хөлс болон нэмэгдэл урамшлын зардлаас 825.8 мянган төгрөгийг хассан.

**2018 онд** улсын төсвөөс авах санхүүжилтийг 285,624.7 мянган төгрөгөөр төлөвлөж, төсвийн тодотголоор 6,240.3 мянган төгрөг нэмж, 291865.0 мянган төгрөгөөр баталсан байна.

Гүйцэтгэлээр санхүүжилтийг батлагдсаны дагуу бүрэн авч, нийгмийн даатгалын сангаас жирэмсэн амаржсан эхийн болон хөдөлмөрийн чадвар түр алдалтын тэтгэмжид 3822.1 мянган төгрөг, нэмэлт санхүүжилтийн дансаар Боловсрол соёл урлагийн газраас нэмэгдэл цалингийн 603.2 мянган төгрөг орж бүгд 296290.3 мянган төгрөгийн эх үүсвэр бүрдүүлж, зарцуулсан байна.

Батлагдсан төсөвт орсон өөрчлөлтийг зардлын ангиллаар нь харуулбал: цалин хөлс болон нэмэгдэл урамшил 5,700.0 мянган төгрөг, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл 684.1 мянган төгрөг, бага үнэтэй түргэн элэгдэх ахуйн эд зүйлс 2,000.0 мянган төгрөг, урсгал засвар 6,560.0 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардал 5,240.2 мянган төгрөг нийт 20,184.3 мянган төгрөгийг нэмж, нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардлаас 5,100.0 мянган төгрөг, хоол хүнсний зардлаас 8,844.0 мянган төгрөгийг хасчээ.

Цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардалд 153974.3 мянган төгрөг, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлд 18632.5 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардалд 51730.4 мянган төгрөг, хангамж бараа материалын зардалд 2484.4 мянган төгрөг, нормативт зардалд 35673.3 мянган төгрөг, урсгал засварын зардалд 6685.3 мянган төгрөг, дотоод албан томилолтын зардалд 84.0 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардалд 196.8 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 3302.8 мянган төгрөг, хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардалд 736.3 мянган төгрөг, хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад таван жил тутамд олгох тэтгэмжид 14872.2 мянган төгрөг, төсвийн дотоод эх үүсвэрээр тоног төхөөрөмж, тавилга эд хогшил худалдан авахад 4095.9 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Булган аймаг байгуулагдсаны 80 жилийн ойд тус цэцэрлэгийн 18 албан хаагчид 2-3 өдрийн цалин 726991 төгрөг хандивласан байна.

Тус цэцэрлэгийн эрхлэгчийн 2018 оны 05 сарын 03-ны өдрийн А/13 дугаар тушаалаар Гамшгаас хамгаалах тухай хуулийн 27.1.5, 27.1.7, 35.1 дэх заалтууд, аймгийн Засаг даргын А/115, сумын Засаг даргын А/51 дугаар захирамжийг Булган аймагт 2018 онд малын гоц халдварт шүлхий өвчин гарсантай холбоотойгоор хорио цээрийн дэглэм тогтоож Булган суманд 11 пост ажиллуулсан. Тус цэцэрлэгээс 11 постод ажилласан давхардсан тоогоор нийт 250 хүний 5 өдрийн өглөө, өдөр, оройн хоолонд төсвөөс 905.5 мянган төгрөгийн хоолны зардал гаргаж, олгосон байна. 03 сарын 04-нд 70 хүнд, 03 сарын 14-нд 60 хүнд, 03 сарын 23-нд 55 хүнд, 04 сарын 01-нд 50 хүнд, 04 сарын 10-нд 15 хүнд тус тус олгожээ.

#### Нэмэлт санхүүжилтийн талаар:

2017 оны 05 сард БСУГазраас улсын математикийн 53-р олимпиадад оролцогчдын хоолны зардалд олгосон 144.0 мянган төгрөгийг Баянхонгор, Говь-Алтай аймгаас олимпиадад оролцохоор ирсэн багш, хүүхдүүдийг өөрийн байгууллагад 5 өдөр байлуулан хоолны зардалд 144.0 мянган төгрөгийг зарцуулсан байна.

2018 онд нэмэгдэл цалинд олгосон 603.2 мянган төгрөгийг тайлант оны 12 сард нийгмийн даатгалын шимтгэлийн зардалд шилжүүлсэн байна.

Шилэн дансны хуулийн хэрэгжилт: Шилэн дансны нэгдсэн сайтад Булган сумын 4-р цэцэрлэг нь 2018 онд мэдээлбэл зохих 151 мэдээллийг бүрэн мэдээлсэн, байршуулах мэдээллээс 2018 оны 03 сард Татварын хэлтсээс хийсэн шалгалтын дүнгээс бусад мэдээллийг бүрэн байршуулсан байна.

Тэтгэмжийн талаар:

Боловсролын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1.7 дахь заалтын дагуу 2017 онд багш Л.Бумбатад 3650.7 мянган төгрөгийн, 2018 онд багш Ж.Отгонжаргалд 3467.0 мянган төгрөг, дуу хөгжмийн багш Б.Сэлэнгэд 3211.8 мянган төгрөг, туслах багш Б.Чимгээд 2814.6 мянган төгрөг, Д.Ариунаад 2814.6 мянган төгрөг, Б.Мөнхсүвдэд 2564.2 мянган төгрөгийн хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласны нэг удаагийн тэтгэмж тус тус олгосон.

Цалин хөлс, нэмэгдэл, урамшууллын талаар:

Эрхлэгч П.Ариунаад аймгийн Засаг даргын 2017 оны А/200, А/514 дугаар захирамжаар 01-12 сард үндсэн цалингийн 15-20 хувиар 1275.9 мянган төгрөг, 2018 оны Б/46, А/574 дугаар захирамжаар 01-12 сард үндсэн цалингийн 25 хувиар 2081.6 мянган төгрөг **нийт 3357.5 мянган төгрөгийн үр чадварын нэмэгдэл**, аймгийн Засаг даргын 2017 оны А/238, А/391, А/512, А/634 дугаар захирамжаар 1-4-р улиралд үндсэн цалингийн 45%-иар, 2018 оны А/233, А/583, А/696, А/712 дугаар захирамжаар 1-4-р улиралд үндсэн цалингийн 25-45 хувиар **нийт 2237.8 мянган төгрөгийн ажлын үр дүнгийн урамшуулалт цалин**, аймгийн Засаг даргын 2018 оны 10 сарын 12-ны А/614 дугаар захирамжаар Гамшгаас хамгаалах команд штабын сургуулийн бэлтгэл ажлыг хангахад идэвхи, зүтгэлтэй оролцсонд нэг сарын үндсэн цалингаар, сумын Засаг даргын 2016 оны Б/25, 2017 оны Б/34 дугаар захирамжаар сумын Засаг даргатай байгуулсан үр дүнгийн гэрээний биелэлтээр “А” үнэлгээгээр дүгнэгдсэнд нэг сарын үндсэн цалингаар буюу **нийт 2059.7 мянган төгрөгийн шагналт**, Монгол Улсын Их Хурлын 2017 оны 11 сарын 09-ны өдрийн 67 дугаар тогтоолыг үндэслэн аймгийн Засаг даргын 2017 оны 12 сарын 21-ний өдрийн А/635 дугаар захирамжаар 300.0 мянган төгрөгийн **урамшуулалт цалин** тус тус олгосон байна.

Мөн Булган сумын Засаг даргын 2018 оны 12 сарын 24-ний Б/17 дугаар захирамжаар сумын Засаг даргатай байгуулсан үр дүнгийн гэрээний биелэлтээр “А” үнэлгээтэй дүгнэгдсэнд нэг сарын үндсэн цалин 711.2 мянган төгрөгөөр шагнаж урамшуулахаар шийдвэрлэснээс 2018 онд 324.2 мянган төгрөгийг, 2019 оны 02 сард 387.0 мянган төгрөгийг олгосон байна.

**2017 онд** цэцэрлэгийн эрхлэгчийн Б/09, Б/19, Б/27, Б/33 дугаар тушаалуудыг үндэслэн 1-р улиралд 17 хүнд 12-42 хувиар тооцож 3014.3 мянган төгрөг, 2-р улиралд 15 хүнд 30-45 хувиар тооцож 2717.5 мянган төгрөг, 3-р улиралд 15 хүнд 20-30 хувиар тооцож 1906.1 мянган төгрөг, 4-р улиралд 16 хүнд 42-45 хувиар тооцож 3381.4 мянган төгрөг нийт 11019.3 мянган төгрөг, **2018 онд** цэцэрлэгийн эрхлэгчийн А/09, А/19, А/26, А/34 дугаар тушаалуудыг үндэслэн ажлын үр дүнгийн

урамшуулал 1-р улиралд 16 хүнд 45-58 хувиар тооцож 3997.3 мянган төгрөг, 2-р улиралд 16 хүнд 40-50 хувиар тооцож 3302.0 мянган төгрөг, 3-р улиралд 16 хүнд 20-45 хувиар тооцож 2833.5 мянган төгрөг, 4-р улиралд 16 хүнд 40-58 хувиар тооцож 4104.4 мянган төгрөг нийт 14237.3 мянган төгрөгийн ажлын үр дүнгийн урамшуулалт цалин тус тус олгожээ.

Монгол Улсын Их Хурлын 2017 оны 11 сарын 09-ны өдрийн 67 дугаар тогтоолыг үндэслэн цэцэрлэгийн эрхлэгчийн 2017 оны 12 сарын 20-ны өдрийн Б/35 дугаар тушаалаар 16 багш, ажиллагсдад 4800.0 мянган төгрөгийн урамшуулалт цалинг нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардлаас гаргаж олгожээ.

Тус цэцэрлэг нь багш ажиллагсдаас тухайн хичээлийн жилийн эхэнд хэн, ямар арга хэмжээ зохион байгуулах талаар саналыг авч, төлөвлөгөө гарган баталж, хариуцсан албан хаагчид сар бүр батлагдсан төлөвлөгөөний дагуу арга хэмжээгээ зохион байгуулдаг байна. Арга хэмжээ зохион байгуулсан албан хаагчдад цэцэрлэгийн эрхлэгчийн тушаалаар 2017 онд үндсэн цалингийн 10-20 хувиар 2111.2 мянган төгрөг, 2018 онд үндсэн цалингийн 20 хувиар 880.2 мянган төгрөгийн ур чадварын нэмэгдэл олгосон байна.

Мөн цэцэрлэгийн эрхлэгчийн тушаалаар 2017 онд СӨБ-ын багш нарын дунд зохион байгуулсан багш олимпиадад амжилттай оролцож 2-р байр эзэлсэн багш Б.Сэлэнгэд үндсэн цалингийн 15 хувиар 80.9 мянган төгрөг, Булган хотын урлагийн наадамд хамт олноо манлайлан амжилттай зохион байгуулсан арга зүйч Б.Нансалмаа, багш Л.Бумбат, С.Цэрэннадмид нарт үндсэн цалингийн 20 хувиар нийт 365.1 мянган төгрөгийн ур чадварын нэмэгдэл, байгууллагын 2017 оны тэргүүнээр багш Ж.Отгонжаргал, сахиул Б.Лодон нарыг шалгаруулж тус бүр 185.0 мянган төгрөгөөр урамшуулсан бол 2018 онд аймгийн цэцэрлэгийн хүүхдүүдийн дунд зохион байгуулсан “Найдвар”, “Бяцхан мисс”, “Булган хангайн хүүхдүүд” урлагийн наадамд тус бүр 1-р байр эзэлсэн багш Б.Сэлэнгэд үндсэн цалингийн 20 хувиар 107.9 мянган төгрөг, аймагт зохион байгуулсан гамшгаас хамгаалах сургалт дадлагад идэвхитэй оролцсон сахиул Б.Лодонд үндсэн цалингийн 20 хувиар 80.7 мянган төгрөг, нярав А.Сувдмаад үндсэн цалингийн 30 хувиар гурван сарын хугацаанд 456.0 мянган төгрөг, улсын тэргүүний цэцэрлэг, улсын тэргүүний багш үзэсгэлэнг амжилттай зохион байгуулсан арга зүйч Б.Нансалмаа, багш Л.Бумбат нарыг үндсэн цалингийн 20 хувиар 268.2 мянган төгрөгийн ур чадварын нэмэгдэл цалин, байгууллагын 2018 оны тэргүүний багшаар Б.Сэлэнгэ, тэргүүний ажилтанаар Б.Мөнхсүвд нарыг шалгаруулж тус бүр 200.0 мянган төгрөгөөр урамшуулсан байна.

Цэцэрлэгийн эрхлэгчийн тушаалыг үндэслэн нягтлан бодогч Д.Баярчимэгт 1-р улирлын үр дүнгийн урамшуулал хавсран ажилласан цалингийн 42 хувиар 94.2 мянган төгрөг, улирал жилийн тайлан баланс, төсвийн төслийг хугацаанд нь үнэн зөв гаргаж, анхан шатны баримтын бүрдлийг тухай бүрд нь хийж гүйцэтгэсэн гэж нягтлан бодогч Б.Эрдэнэчимэгт 2017 оны 10-12 сард хавсран ажилласан цалингийн 20 хувиар 134.6 мянган төгрөг, 2018 оны 4 сард 30 хувиар 67.3 мянган төгрөг, нярав А.Сувдмаад 2017 оны 10-12 сард үндсэн цалингийн 20 хувиар 281.5

мянган төгрөг, 2018 оны 4 сард 30 хувиар 140.7 мянган төгрөгийн ур чадварын нэмэгдэл тус тус олгосон байна.

Тус цэцэрлэгийн эрхлэгчийн 2018 оны 05 сарын 25-ны өдрийн А/16 тушаалаар аймгийн 80 жилийн ойг тохиолдуулан гадаах тоглоомын талбайг шинээр стандартад нийцүүлэн хийж хүүхэд тоглох хөгжих орчинг бүрдүүлэн ногоон байгууламж бий болгосон 16 багш, ажиллагсдыг 1000.0 мянган төгрөгөөр урамшуулсан байна.

2017 онд 700.0 мянган төгрөг, 2018 онд 650.0 мянган төгрөгийн цалингийн урьдчилгаа олгож бүрэн суутгасан байна.

### **6.2 Өглөг, авлагын талаар:**

Авлагын хувьд: 2017 онд 72.2 мянган төгрөгийн авлагатай байсныг тайлант онд барагдуулж оны эцэст авлагагүй. 2018 оны эцэст НДХэлтэсээс шимтгэлийн авлага 31.2 мянган төгрөг, Татварын хэлтсээс ХХОАТатварын авлага 21.3 мянган төгрөг нийт 52.6 мянган төгрөгийн авлагатай.

*Өглөгийн хувьд:* Арвайн эхлэл ХХК-д өгөх 142.4 мянган төгрөгийн хүнсний өглөгийг тайлант оны 03 сард барагдуулж оны эцэст өглөггүй. 2018 онд өглөггүй тайлан баланс гаргасан байна.

### **6.3. Үндсэн хөрөнгийн хөдлөл өөрчлөлт:**

2017 оны эхний үлдэгдэл 415862.9 мянган төгрөгийн хөрөнгө дээр төсвийн хөрөнгөөр Нэкст электроникс ХХК-иас 369.9 мянган төгрөгөөр принтер, Тулга төхөөрөмж ХХК-иас 568.0 мянган төгрөгөөр аяга ариутгагч, 1980.0 мянган төгрөгөөр ногоо арилгагч, 3730.0 мянган төгрөгөөр нэгдүгээр хоолны тогоо, 580.0 мянган төгрөгөөр гурил зуурагч, 642.0 мянган төгрөгөөр 2 ш бэлтгэлийн ширээ, иргэн Г.Сарантуяагаас 4656.0 мянган төгрөгөөр 42 м дрож, 1600.0 мянган төгрөгөөр нэгдүгээр хоолны тогоо, 400.0 мянган төгрөгөөр буузны жигнүүр, 630.0 мянган төгрөгөөр хөлдөөгч, 550.0 мянган төгрөгөөр уур гаргагч, 220.0 мянган төгрөгөөр өлгүүр худалдан авч, ДЗОУБайгууллагаас 746.6 мянган төгрөгийн үнэтэй бичгийн ширээ, шкаф, бичгийн шкаф, сандал, бичгийн шүүгээ, шүүгээ, тавиур гэсэн 7 нэр төрлийн 7 ш тавилга хэрэгсэл үнэ төлбөргүйгээр өгч нийт 16672.5 мянган төгрөгийн хөрөнгө нэмэгдэж, цэцэрлэгийн эрхлэгчийн 2017 оны 12 сарын 22-ны А/11 дугаар тушаалаар эдэлгээ нь дуусч, цаашид ашиглах боломжгүй болсон 1600.0 мянган төгрөгийн үнэтэй нэгдүгээр хоолны тогоо, 839.9 мянган төгрөгийн үнэтэй компьютерыг актлан данс бүртгэлээс хасч оны эцэст 430095.5 мянган төгрөгийн хөрөнгийн үлдэгдэлтэй байна.

2018 оны эхний үлдэгдэл 430095.5 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө дээр БСБ электроникс ХХК-иас 339.9 мянган төгрөгөөр принтер, 849.9 мянган төгрөгөөр зөөврийн компьютер, Гүрсоронзон ХХК-иас 607.1 мянган төгрөгөөр хөлдөөгч, иргэн Б.Тунгалагтамираас 2299.0 мянган төгрөгөөр 22 м дрож нийт 4095.9 мянган төгрөгөөр худалдан авсан, тус цэцэрлэгийн эрхлэгчийн 2018 оны 12 сарын 26-ны Б/09 дугаар тушаалаар эдэлгээ нь дуусч, ашиглалтын шаардлага хангахгүй болсон 3146.0 мянган төгрөгийн үнэтэй нэгдүгээр хоолны тогоо, 290.0 мянган төгрөгийн үнэтэй принтер, 894.6 мянган төгрөгийн үнэ бүхий 3 нэр төрлийн 26 ш тавилга эд

хогшлыг актлан данс бүртгэлээс хасч, оны эцэст 203882.4 мянган төгрөгийн хөрөнгийн үлдэгдэлтэй байна.

Засгийн газрын 2016 оны 193 дугаар тогтоолын дагуу эргэлтийн бус хөрөнгө болох газар, барилга байгууламжид дахин үнэлгээг хийсэн байна. Барилга байгууламжид хийсэн дахин үнэлгээгээр барилга байгууламжийн бодит үнэ цэнэ 115485.7 мянган төгрөг, инженерийн байгууламжийн бодит үнэ цэнэ 1488.5 мянган төгрөг, 2 ширхэг нийтийн эзэмшлийн байгууламжийн бодит үнэ цэнэ 1986.2 мянган төгрөгөөр, байгууллагын эзэмшлийн 1 ширхэг 3335 м.кв газрын эзэмших эрхийн бодит үнэ цэнэ 33350.0 мянган төгрөгөөр тус тус үнэлэгдсэн байна.

#### **6.4. Бараа материалын хөдлөл өөрчлөлт:**

2017 оны эхний үлдэгдэл 33322.5 мянган төгрөг дээр 644.1 мянган төгрөгөөр бичиг хэрэг, 789.4 мянган төгрөгөөр аж ахуйн, 1705.5 мянган төгрөгийн түлш, шатах тослох материал, 38086.6 мянган төгрөгөөр хүнс, 2429.4 мянган төгрөгөөр засварын материал, 4143.2 мянган төгрөгөөр бусад хангамжийн материал худалдан авч, 44229.4 мянган төгрөгийг үйл ажиллагаандаа зарцуулж, цэцэрлэгийн эрхлэгчийн 2017 оны А/05, А/11 дугаар тушаалаар тоглоом, ном, бусад хангамжийн материалаас ашиглалтын шаардлага хангахгүй болсон 252 нэр төрлийн 866 ш 7933.5 мянган төгрөгийн бараа материалыг актлан данс бүртгэлээс хасч оны эцэст 28957.9 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

2018 оны эхний үлдэгдэл 28957.9 мянган төгрөг дээр 1102.9 мянган төгрөгөөр аж ахуйн, 708.6 мянган төгрөгөөр бичиг хэрэг, 410.9 мянган төгрөгөөр түлш шатах тослох материал, 3578.9 мянган төгрөгөөр засвар, 35034.1 мянган төгрөгөөр хүнс, 6826.9 мянган төгрөгөөр бусад хангамжийн материал нийт 47662.3 мянган төгрөгөөр худалдан авч, 44730.0 мянган төгрөгийг үйл ажиллагаандаа зарцуулж, тус цэцэрлэгийн эрхлэгчийн 2018 оны Б/06, Б/09 дугаар тушаалаар тоглоом, ном, бусад хангамжийн материалаас ашиглалтын шаардлага хангахгүй болсон 177 нэр төрлийн 584 ш 5959.3 мянган төгрөгийн бараа материалыг актлан данс бүртгэлээс хасч оны эцэст 25930.8 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлан гарчээ.

### **ДОЛОО. ШАЛГУУЛАГЧИЙН ОЛОЛТТОЙ БОЛОН ДЭВШИЛТТЭЙ ТАЛ**

Анхан шатны баримт, баримтын бүрдүүлэлт, нягтлан бодох бүртгэлийн хөтлөлт хангалттай, санхүүгийн тайлан, мэдээг хугацаанд нь гаргаж холбогдох байгууллагаар хянуулан баталгаажуулсан, хүүхдийн хоолны цэсийг долоо хоног бүр тогтмол гаргаж удирдлагаар баталгаажуулсан сайн талтай байна.

#### **НАЙМ. ШАЛГАЛТААР ИЛЭРСЭН ЗӨРЧИЛ, ТҮҮНИЙ ШАЛТГААН, ЗӨРЧИГДСЭН ХУУЛЬ, ТОГТООМЖ**

1. Булган сумын 4-р цэцэрлэгийн эрхлэгчийн 2017 оны 04 сарын 27-ны өдрийн Б/14 дугаар тушаалаар туслах багш Б.Мөнхсүвд, сахиул Б.Лодон нарт сахилгын шийтгэл ногдуулж сануулах арга хэмжээ авсан атал цэцэрлэгийн эрхлэгчийн 2017 оны 12 сарын 20–ны өдрийн Б/35 дугаар тушаалаар Улсын Их Хурлын 2017 оны 11 сарын 09-ний өдрийн 67 дугаар тогтоолыг үндэслэн сахилгын шийтгэл хүлээсэн туслах багш Б.Мөнхсүвд, сахиул Б.Лодон нарт нийт 600.0 мянган төгрөгийн



урамшуулалт цалин олгосон нь Монгол улсын Засгийн газрын 2017 оны 12 сарын 06-ны өдрийн 52 дугаар хуралдааны тэмдэглэлийг зөрчсөн байна.

**2.** Байгууллагын даргын тушаалаар аймгийн ИТХурлын Тэргүүлэгчдийн 2000 оны 96 тоот тогтоол /хүчингүй болсон/, өмч хамгаалах байнгын зөвлөлийн дүгнэлт үндэслэлгүй 2017 онд 10373.4 мянган төгрөгийн, 2018 онд 10289.9 мянган төгрөгийн эд хөрөнгийг акталж данс бүртгэлээс хассан, актлах эд хөрөнгийг зургаар баталгаажуулсан боловч ямар эд хөрөнгө болох нь мэдэгдэхгүй, тайлбар, тодруулга хийгээгүй шаардлага хангахгүй баримт санхүүгийн баримтад хавсаргасан, өмч хамгаалах байнгын зөвлөлөө ажиллуулаагүй байгаа нь аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 01 сарын 23-ны өдрийн 17 дугаар тогтоол “Орон нутгийн өмчит хуулийн этгээд үндсэн хөрөнгө олж авах, худалдах, шилжүүлэх, актлах журам”-ын 6.2-д /Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн эргэлтийн хөрөнгөд хамаарах эд хөрөнгийг актлах асуудлыг өмч хамгаалах байнгын зөвлөлийн дүгнэлтийг үндэслэн байгууллагын даргын тушаалаар шийдвэрлэнэ./ заасан заалтыг мөрдөж ажиллаагүй.

**3.** Иргэн Г.Сарантуяагаас 1600.0 мянган төгрөгийн үнэтэй нэгдүгээр хоолны тогоо 2017 оны 05 сарын 14-нд худалдан авсан боловч тооллогын комиссын илтгэх хуудас, хурлын тэмдэглэлд буй “цахилгааны хүчдэлээс болж шатсан, цаашид ашиглах боломжгүй болсон” гэх шалтгаан, эд хариуцагчийн буруутай үйлдлээс үү, ашиглалтын явцад эвдэрсэн үү зэргийг тогтоосон, нотолсон анхан шатны баримт байхгүй, өмч хамгаалах зөвлөлийн хурлын шийдвэр гараагүй байхад эд хөрөнгийн тооллогын комиссын шийдвэрийг үндэслэн байгууллагын даргын тушаалаар актлан данс бүртгэлээс хассан, уг хөрөнгийг “Үндсэн хөрөнгө хүлээн авах,...баримт” анхан шатны баримтаар хүлээн аваагүй нь аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 01 сарын 23-ны өдрийн 17 дугаар тогтоолоор баталсан “Орон нутгийн өмчит хуулийн этгээд үндсэн хөрөнгө олж авах, худалдах, шилжүүлэх, актлах журам”-ын 6.2 дахь заалт, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар баталсан заавар, журмын 5.1 дэх заалтуудыг зөрчсөн.

**4.** Тус цэцэрлэгийн эрхлэгчийн 2018 оны 12 сарын 26-ны Б/09 дугаар тушаалаар 3146.0 мянган төгрөгийн дансны үнэтэй, 2011 онд ашиглалтад орж 2462.7 мянган төгрөгийн элэгдэл тооцож, 683.3 мянган төгрөгийн үлдэх өртөгтэй нэгдүгээр хоолны тогоог “шатсан, дахин засвар авах боломжгүй болсон” гэх тооллогын комиссын шийдвэрийг үндэслэн актлаж, данс бүртгэлээс хассан байна. 3.0 сая төгрөгөөс дээш үнэтэй орон нутгийн өмчит үндсэн хөрөнгийг актлуулах асуудлыг аймгийн Орон нутгийн өмчийн газраар шийдвэрлүүлэх байтал тус байгууллага эрх хэмжээнээсээ давсан шийдвэр гаргасан, аймгийн Орон нутгийн өмчийн газар хяналт тавиагүй байгаа нь аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 01 сарын 23-ны өдрийн 17 дугаар тогтоолоор баталсан “Орон нутгийн өмчит хуулийн этгээд үндсэн хөрөнгө олж авах, худалдах, шилжүүлэх, актлах журам”-ын 6.1-д /Орон нутгийн өмчит хуулийн этгээд нь жилийн эцсийн хөрөнгийн тооллогын дүн, Өмч хамгаалах байнгын зөвлөлийн дүгнэлтийг үндэслэн ашиглалтын шаардлага хангахгүй болсон үндсэн хөрөнгийг актлах саналаа Өмчийн албанд албан бичгээр ирүүлнэ...../, 6.1.1-д /Барилга байгууламж, тээврийн хэрэгсэл, түүх соёлын ховор, үнэт, дурсгалт зүйлсээс бусад анхны үнэ 3 000 000 төгрөгөөс доош орон нутгийн өмчит үндсэн хөрөнгийг сум, байгууллага

бие дааж шийдвэрлэнэ./, 7.1-д /Эрх бүхий байгууллагаас гаргасан орон нутгийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийг .....актлах шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг тухайн хуулийн этгээдийн дарга, /эрхлэгч/..... нь Өмч хамгаалах байнгын зөвлөлтэй хамтран байгууллага дээрээ зохион байгуулах бөгөөд Өмчийн алба хяналт тавина./ заасан заалтуудыг хэрэгжүүлж ажиллаагүй.

5. Удирдлагын гаргасан шийдвэр бичиг хэргийн стандарт хангаагүй, зарим шийдвэрт хүчингүй болсон эрх зүйн акт үндэслэсэн, үр дүнгийн урамшуулал олгохоор батлагдсан тушаалын хавсралт санхүүгийн баримт, үдэгдэж архивлагдсан тушаалд хоёр өөр дүнгээр, аймгийн 80 жилийн ой, “Цэвэр орчин-Цэмцгэр Булган” аяны хүрээнд тоглоомын талбайд бүтээн байгуулалт хийсэн албан хаагчдыг шагнаж урамшуулахаар төлөвлөсөн байтал ур чадварын нэмэгдэл олгох эрх зүйн акт үндэслэсэн.

6. Цалин олгох хүснэгт, цалингийн карт, гарт олгох хүснэгтэд гарын үсгийн бүрдэл дутуу зурагдсан, орлогын баримтыг бараа материалын данс, дансаар хөтөлдөггүй, гарт олгох цалингийн жагсаалтыг банк тус бүрээр нь зөвхөн нэг хувь гаргаж банкуудад өгч санхүүгийн баримтад үдэж архивлаагүй, албан томилолтоор ажилласан албан хаагчийг ажилдаа ирсэнээр бүртгэсэн, цагийн бүртгэлийг батлагдсан маягтын дагуу бүрэн хөтлөөгүй, эрхлэгч П.Ариунаагийн 2018 оны жилийн эцсийн үр дүнгийн урамшуулалд 387.0 мянган төгрөг дутуу олгосныг тайлан балансад өглөгөөр тусгаагүй, чөлөө олгохыг хүссэн өргөдөлд цалинтай, цалингүй алин болох нь тодорхойгүй “чөлөө олгоё” гэж цохолт хийсэн, багш нар ирцийн бүртгэлийг засвартай үйлдсэн, тухайн сард хүүхэд хичнээн өдөр өвчтэй, чөлөөтэй, тасалсан болохыг дүгнээгүй, хүүхдийн хоногийн хоолны нормыг хүчингүй болсон эрх зүйн актыг баримталж олгосон байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1, 13.5, 13.6, 14.4.3-д заасан заалтуудыг хэрэгжүүлээгүй.

7. Шилэн дансны нэгдсэн сайтад тус цэцэрлэг нь 2018 онд мэдээлбэл зохих 151 мэдээллээс 2018 оны 03 сард Татварын хэлтсээс хийсэн шалгалтын дүнг байршуулаагүй байгаа нь Шилэн дансны тухай хуулийн 6.4.6-д /Худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт шалгалтын дүнг долоо хоногийн дотор мэдээлнэ./ заасан заалтыг мөрдөөгүй байна.

#### ЕС. АВСАН АРГА ХЭМЖЭЭ, МЭРГЭЖЛИЙН ТУСЛАЛЦАА, ЗӨВЛӨГӨӨ ӨГСӨН БАЙДАЛ

Санхүүгийн үйл ажиллагаанд хийгдсэн хяналт шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулахаар улсын ахлах байцаагчийн 5 актаар 2244.7 мянган төгрөгийн төлбөр тогтоосноос 468.4 мянган төгрөгийг нөхөн олгох, 1776.3 мянган төгрөгийг төсвийн орлогод төвлөрүүлэх, улсын байцаагчийн 1 албан шаардлага үйлдэж, санхүү, бүртгэлийн 3 албан тушаалтанд мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөв.

#### АРАВ. ДҮГНЭЛТ

Тус байгууллагын анхан шатны баримтын бүрдэлт, нягтлан бодох бүртгэлийн хөтлөлт хангалттай, санхүү, нягтлан бодох бүртгэлийн чиглэлээр дотоодын хяналтыг хэрэгжүүлээгүй байна гэж дүгнэлээ.

## АРВАН НЭГ. ЦААШИД АНХААРАХ АСУУДАЛ

Монгол улсын Нягтлан бодох бүртгэлийн тухай, Төсвийн тухай хуулийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлж ажиллах

Санхүүгийн үйл ажиллагаандаа дотоодын хяналт шалгалтыг тогтмол хийж санхүүгийн сахилга хариуцлагыг дээшлүүлэх

Шилэн дансны тухай хууль, журам, захирамж, шийдвэрүүдийг хэрэгжүүлж биелэлтийг тооцож, хариуг улирал тутам бичгээр ирүүлэх

Илэрсэн зөрчлүүдийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх талаар анхааран тодорхой ажил зохион байгуулж, албан шаардлагын биелэлтийг албан тоотоор хүргүүлэх

БИЧСЭН:

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН  
УЛСЫН БАЙЦААГЧ

Ж.ОЮУН



